

**2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 17-НЫ ӨДРИЙН ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧООС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2023 оны 04 дүгээр сарын 21-ний “Баасан” гарагийн 12:00 цагаас өмнө e-doc системээр албан бичгээр ирүүлж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцно.

Биелэлтийг ирүүлэхдээ үүрэг даалгавар бүрийн хэрэгжилтийн хувийг тодорхой бичиж ирүүлнэ үү.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД		
1.	2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулагдах “Улаанбаатар - Олон улсын хөрөнгө оруулалт, түншлэлийн форум”-ын бэлтгэл ажлыг сайтар хангаж, идэвхтэй оролцох. Форумын үеэр байгуулагдах санамж бичиг, гэрээний төслүүдийг форумын ажлын хэсэгт хүргүүлэх	ЗДТГ
2.	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” А/378 дугаар захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, ажлын уялдаагаа хангаж ажиллах, дүүрэгт он дамжин хийгдэж буй ажлуудын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах	ЗДТГ, ХААА
ЦАГ ҮЕИЙН АСУУДЛЫН ХҮРЭЭНД		
3.	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/242 дугаар захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, аж ахуйн нэгж байгууллагуудад барилгын чанар, стандартын хэрэгжилтийг хангуулах зөвлөмж хүргүүлэх.	ТХҮХ,
4.	Өргөдөл гомдлын талаар шинэ шийдлийн системийг танилцуулах.	ТЗУХ, ААНБ-ууд
5.	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” А/309 дүгээр захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд таниулан сурталчлах ажлыг зохион байгуулах.	ОБХ
6.	Хүүхэд, залуучуудын хөдөлгөөн ихсэж байгаатай холбогдуулан гэмт хэрэг, зөрчил болон зам, тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын нэгдсэн арга хэмжээг улирал бүр зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	Цагдаагийн хэлтэс, ГБХЗХХ, Боловсролын хэлтэс
7.	Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хэсгийг дүүрэг тус бүрт байгуулж, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/243 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэгтэй үйл ажиллагаагаа уялдуулж, ажлын явц, үр дүнг 14 хоног тутамд нийслэлийн ажлын хэсэгт танилцуулж ажиллах.	ЗДТГ

ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

8.	Цахим хөгжил, харилцаа холбооны яам, нийслэлийн Засаг дарга хамтран хэрэгжүүлж буй цахим шилжилттэй холбоотой “Digital Ulaanbaatar” хөтөлбөрийн хүрээнд 5 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулагдах уулзалтын бэлтгэлийг ханган, идэвхитэй оролцох.	ТЗУХ, НХХ, ААНБ-ууд
9.	Веб сайтын ажиллагааг шинэчлэх, тогтмолжуулах талаар арга хэмжээг зохион байгуулж, тогтоосон хугацаанд танилцуулж ажиллах.	ТЗУХ
10.	2022 оны Санхүүгийн нэгдсэн аудитын дүгнэлтээр гарсан зөрчлийг энэ онд давтахгүй талаар арга хэмжээ зохион байгуулж, хяналтыг сайжруулж ажиллах	СТСХ
11.	2023.04.19-ний өдөр зохион байгуулагдах ДИТХ-ын ээлжит бус 19-р чуулганы бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллах.	ЗДТГ
12.	2023.04.29-ний өдөр зохион байгуулагдах “Багахангай марафон-2023” УАШТ-ий бэлтгэл ажлыг хангаж ажиллах	НХХ
13.	“Оюунлаг Багахангайчууд” арга хэмжээний хүрээнд 04 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулагдах “Мэтгэлцээн”-ий тэмцээнд идэвхитэй оролцох	НХХ, ААНБ-ууд
14.	Чингис хаан музейн сургалт, танин мэдэхүйн төв байгуулахтай холбогдсон хамтын ажиллагааны гэрээ байгуулах талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх	ТЗУХ, НХХ